

## 1. Ерөнхий

- 1.1 “Цахим Дижитал Гараж” ХХК-ийн албан ёсны бүтээгдэхүүн “Digital Garage-Дижитал Гараж” нь авто үйлчилгээний худалдаа болон үйлчилгээний цахим орон зайг бий болгож, худалдаа, үйлчилгээг цахимаар авах болон дата өгөгдлөө нэгдсэн байдлаар удирдах боломжийг олон нийтэд хүргэнэ.
- 1.2 Үйлчилгээний нөхцөл нь цахим авто үйлчилгээний худалдааны системд Албан ёсны гэрээт борлуулагчаас бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах, Хэрэглэгч худалдан авахтай холбоотой үүсэж буй харилцааг зохицуулна.
- 1.3 Үйлчилгээний нөхцөлд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - “Цахим худалдааны систем” гэж Албан ёсны гэрээт борлуулагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг Хэрэглэгчдэд санал болгох, худалдан авалтыг цахимаар хийх үйлчилгээг бүрдүүлсэн цахим вэб хуудас <https://garage.mn/> болон ухаалаг утсанд зориулсан Дижитал Гараж гар утасны аппликейшнийг (цаашид “**Digital Garage**” гэх);
  - “Хэрэглэгч” гэж Үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, “Digital Garage”-г хэрэглэж буй иргэний эрх зүй бүрэн чадамжтай иргэн, хуулийн этгээдийг;
  - “Албан ёсны гэрээт борлуулагч” гэж Бараа бүтээгдэхүүн борлуулах болон үйлчилгээ үзүүлэх албан ёсны эрхтэй гэрээ байгуулсан хуулийн этгээд, хувь хүнийг;
  - “Албан ёсны гэрээт авто үйлчилгээ үзүүлэгч” гэж Авто үйлчилгээ үзүүлэх албан ёсны эрхтэй гэрээт хуулийн этгээд, хувь хүнийг;
  - “Цахим гарын үсэг” гэж Хэрэглэгчийг танин баталгаажуулах үйл ажиллагаанд хэрэглэж буй нэвтрэх нууц үг, баталгаажилтын нэг удаагийн нууц үг, бусад цахим өгөгдлийг тус тус ойлгоно.
- 1.4 Хэрэглэгч нь “Digital Garage”-д нэвтэрч, бүртгүүлэхээс өмнө Үйлчилгээний нөхцөл, Нууцлалын бодлоготой бүрэн танилцах үүрэгтэй. Үйлчилгээний нөхцөл, Нууцлалын бодлоготой бүрэн танилцаж, эдгээр нөхцөл, бодлогод заасан нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд “Би хүлээн зөвшөөрч байна.” гэсэн товчийг идэвхжүүлснээр Хэрэглэгчийг зөвшөөрсөнд тооцно.
- 1.5 Хэрэв Хэрэглэгч Үйлчилгээний нөхцөл, Нууцлалын бодлогыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд хүлээн зөвшөөрөхөөс татгалзах эрхтэй. Татгалзсан тохиолдолд “Digital Garage”-г зориулалтын дагуу бүрэн ашиглах боломжгүй болох үр дагавар үүсэхийг анхаарна уу.
- 1.6 “Digital Garage” нь Албан ёсны гэрээт борлуулагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг Хэрэглэгчид хүргэж, танилцуулах болон худалдан авалтыг цахимаар хийх боломжийг өөрсдийн цахим худалдааны системээр дамжуулан Хэрэглэгчид олгоно.
- 1.7 “Digital Garage”-д байршуулсан бараа бүтээгдэхүүнийг шууд нийлүүлэх, очиж авах (бэлэн бараа), үйлдвэрээс нийлүүлэх гэж ангилна.

- 1.8 Үйлдвэрээс нийлүүлэх бараа бүтээгдэхүүний хувьд тээвэрлэлт болон хил, гаалийн үйл ажиллагааны улмаас барааг хэрэглэгчид хүргэх хоног тодорхой хугацаагаар саатаж болзошгүй тухай Албан ёсны гэрээт борлуулагчийн мэдээллийг үндэслэн тухай бүр “Digital Garage”-аас Хэрэглэгчид мэдэгдэнэ. Хэрэглэгч та тухайн мэдээлэл дээр үндэслэн шийдвэрээ гаргах бөгөөд бидний зүгээс энэхүү өөрчлөлттэй холбоотой мэдээллийн зөрүүтэй байдлаас үүссэн аливаа эрсдэл болон хариуцлагыг хүлээхгүй болно.
- 1.9 Хэрэглэгч нь иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байх бөгөөд насанд хүрсэн хувь хүн эсхүл хуулийн этгээд байна. Насанд хүрээгүй хүүхэд хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх), харгалзан дэмжигч, асран хамгаалагчийн хамт үйлчилгээний нөхцөлийн дагуу зөвхөн худалдан авалт хийх боломжтой.
- 1.10 Үйлчилгээний нөхцөлийн хэрэгжилтэд “Цахим Дижитал Гараж” ХХК болон Хэрэглэгч нар нь хамтран хяналт тавина.
- 1.11 Та зарим төрлийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах насанд хүрээгүй нөхцөлд “Digital Garage”-ийн зүгээс танд санал болгох, худалдах боломжгүй. Жишээлбэл: 18 насанд хүрээгүй бол авто үйлчилгээний бүтээгдэхүүн худалдан борлуулахгүй гэх мэт.

## 2. Хэрэглэгч болон бүртгүүлэх

- 2.1 Хэрэглэгчээр бүртгүүлэхдээ “Digital Garage”-ийн Нэвтрэх хэсгийг сонгон “Нэвтрэх” болон “Бүртгүүлэх” гэсэн сонголтын аль нэгийг сонгож өөрийн утасны дугаар болон нууц үгээ оруулан хэрэглэгчийн профайлаа нээнэ. Хэрэглэгч нь өөрийн хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.
- 2.2 “Digital Garage”-д бүртгэлтэй утасны дугаараар нэвтрэх боломжтой.
- 2.3 “Digital Garage”-д Хэрэглэгчээр бүртгүүлснээр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ захиалах, хүслийн жагсаалт үүсгэх, Халаасны инженер OBD оношлогоо хийх, өөрийн захиалгыг хянах эрх үүснэ.
- 2.4 Хэрэглэгч нь “Digital Garage”-д нэвтрэх бүртгэлтэй утасны дугаар, нууц үгийг бусдад дамжуулахгүй байх, үүнтэй холбоотой учирч болох аливаа эрсдэлээс сэргийлэх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүй буюу хангалтгүй биелүүлсний улмаас өөрт болон бусдад учирсан аливаа хохирлыг Хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.
- 2.5 Хэрэглэгч “Digital Garage”-н талаар санал гомдол, шинэ санаа, шинэ бараа, үйлчилгээ борлуулах хүсэлт, шүүмж зэргийг чөлөөтэй илэрхийлэх, илгээх эрхтэй бөгөөд [www.garage.mn](http://www.garage.mn) дээрх онлайн туслах, <https://www.facebook.com/digital.garage.mn> -д хандан мессэж илгээх, [info@garage.mn](mailto:info@garage.mn) цахим хаяг, эсвэл хэрэглэгчийн тусламж хэсгээс “Санал хүсэлт илгээх” формыг бөглөн илгээх боломжтой.
- 2.6 Хэрэглэгч нь өөрийн мэдээллийн үнэн зөв, бодит байдалд бүрэн хариуцлага хүлээнэ.
- 2.7 “Digital Garage.mn”-н хэвийн ажиллагаа, түүний мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг “Цахим Дижитал Гараж” ХХК хариуцна.

### 3. Захиалга хийх, баталгаажих, цуцлах хугацаа

#### 3.1 Захиалга хийх хугацаа:

- Хэрэглэгч “Digital Garage” цахим авто үйлчилгээний худалдааны системийг ашиглан 24 цагийн аль ч цагт хэдэн удаа ч захиалга хийж болно.

#### 3.2 Захиалга баталгаажих, цуцлагдах хугацаа:

- Хэрэглэгч нь захиалга хийснээс хойш 30 минутын дотор зааврын дагуу төлбөрийг бүрэн шилжүүлснээр захиалга баталгаажна. “Digital Garage”-д захиалга баталгаажсанаар Хэрэглэгч болон Албан ёсны борлуулагч нарын хооронд гэрээ байгуулагдсан гэж үзнэ.vibvi
- Захиалгын төлбөр 30 минутын дотор холбогдох дансанд орж ирээгүй тохиолдолд захиалга автоматаар цуцлагдана. Нэгэнт цуцлагдсан захиалгыг дахин сэргээх боломжгүй бөгөөд Хэрэглэгч хүсвэл захиалгыг дахин шинээр үүсгэх боломжтой.
- Хэрэглэгч 30 минутын дотор төлбөрийг гүйцэтгэж чадаагүйн улмаас захиалга цуцлагдсан тохиолдолд “Цахим Дижитал Гараж” ХХК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

#### 3.3 Хэрэглэгч нь ажлын өдрүүдэд 10:00-19:00 цагийн хооронд (цайны цаг 12:30-13:30), амралтын өдрүүдэд 11:00-18:00 цагийн хооронд лавлах 7200-3003 дугаараар холбогдож мэдээлэл авах, тодруулах бүрэн боломжтой.

#### 3.4 Захиалгын бараа хүргэгдэх, авто үйлчилгээ үзүүлэх хугацаа:

- “Digital Garage” нь Хэрэглэгчийн хийсэн захиалгын төлбөр албан ёсны дансанд тодорхой заавар, хэлбэрийн дагуу хийгдсэн үеэс эхлэн захиалга албан ёсоор хийгдэж баталгаажсан гэж үзнэ.
- Захиалга хийх, төлбөрийг шилжүүлэх, бараа, бүтээгдэхүүн хүлээж авах бүрд Хэрэглэгчийн бүртгүүлсэн гар утсанд “Digital Garage”-аас мэдэгдэл илгээнэ.
- Захиалгыг баталгаажуулсан хугацаа, тээвэрлэлт, аюулгүй байдал зэргээс хамаарч захиалгын төлбөрийг бүрэн төлсөн өдрөөс хойш бэлэн барааг Улаанбаатар хотод А бүсэд энгийн хүргэлт бол 24-48 цагт, шуурхай хүргэлт бол 2-5 цагт, Б бүсэд энгийн хүргэлт бол 48-72 цагт, шуурхай хүргэлт 5-6 цагт, хөдөө, орон нутгийн хүргэлт бол 24-48 цагт багтаан унаанд тавиж өгч явуулна.
- Хэрэглэгч бараа бүтээгдэхүүний захиалгын төлбөрийг цахим зээлийн үйлчилгээгээр төлөх нөхцөлд банк таны зээлийн хүсэлтийг баталсан цагаас хойш 24-72 цагийн дотор захиалсан бараа бүтээгдэхүүнийг хүргэнэ.
- Авто үйлчилгээний оношилгоо болон засвар үйлчилгээ сонгосон нөхцөлд авто үйлчилгээ үзүүлэгч 24-72 цагийн дотор захиалгад заасан үйлчилгээний цагийг баталгаажуулна. Авто үйлчилгээ үзүүлэх баталгаажсан цагийг авто

үйлчилгээ үзүүлэгч өгнө. Хэрэглэгч баталгаажсан авто үйлчилгээний цагтаа очоогүйгээс шалтгаалан үүсэх эрсдэл болон хариуцлагыг хэрэглэгч хүлээнэ.

- Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, бүх нийтийн амралтын өдрүүд, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр хил, гаалийн үйл ажиллагаа саатах, цаг агаарын байдал, хорио цээрийн дэглэм тогтоосон, гамшгийн нөхцөл байдал үүссэн болон бусад хүчин зүйлийн улмаас тээвэрлэлт саатах зэрэг шалтгаанаар тодорхой хугацаагаар захиалгын хүргэлт саатах бүрд хэрэглэгчид нэн даруй мэдэгдэнэ. Эдгээр нөхцөл байдлууд арилж, захиалгыг хүргэх боломж бүрдэх хүртэл хүргэлтийн хугацаа хойшлогдоно.

### **Онцгой бараа:**

- Барааны төрөл, хэлбэр, жин, овор хэмжээнээс хамааран захиалга болон хүргэлт хийх хугацаа өөр байх боломжтой. Хэрэв Хэрэглэгчийн хийсэн захиалгын бараа онцгой шинж чанартай байх тохиолдолд тухайн үед нь Хэрэглэгчид мэдэгдэх, тодруулах, захиалгыг дахин баталгаажуулж хүргэлтийн нөхцөлийг тодорхойлох болно.

### **3.5 НӨАТ-ын цахим баримт илгээх тухай**

- Захиалгын цахим төлбөрийн и-баримт нь “Цахим Дижитал Гараж” ХХК-ийн үйл ажиллагааны чиглэл буюу цахим худалдааны онцлогоос хамааран үйлчилгээний нөхцөлийн 7-р заалтад заасны дагуу захиалга хүргэгдсэнээс хойш хуанлийн 72 цагийн дотор Хэрэглэгчийн бүртгэлтэй цахим хаягт болон Хэрэглэгчийн профайл хэсэгт нэгэн зэрэг илгээгдэнэ.
- НӨАТ төлөгч биш байгууллагын бараа бүтээгдэхүүний захиалгын и-баримт нь зөвхөн сугалааны эрхтэй илгээгдэнэ.
- Дээрх нөхцөлүүд нь хувь хүн болон байгууллагын НӨАТ-ын цахим баримтад хамааралтай болно.

## **4. Төлбөр төлөх, захиалга цуцлах**

- 4.1 Хэрэглэгч захиалга хийж баталгаажуулсны дараа цахим хэлбэрээр захиалгын хуудасны мэдээлэл авна. Мөн “Digital Garage” нь захиалгыг баталгаажуулж байх хугацаанд захиалгын нийт дүн, төлбөр гүйцэтгэх хэлбэр, төлбөр хүлээн авагч Байгууллагын нэр, дансны дугаар зэргийг Хэрэглэгчдэд ойлгомжтой хэлбэрээр хүргэнэ.
- 4.2 Хэрэглэгчийн хийсэн захиалга бүр дахин давтагдашгүй захиалгын дугаартай байх бөгөөд “Идэвхтэй захиалга” болон “Захиалгууд” хэсгээс захиалгын тухай дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.

- 4.3 Захиалга хийгдсэнээс хойш 30 минутын дотор Хэрэглэгч нь төлбөрийг хүлээн авагчийн дансанд шилжүүлэх, байршуулах шаардлагатай. Төлбөрийг шилжүүлэх, байршуулахад системд заагдсан зааврыг зайлшгүй дагаж мөрдөнө.
- 4.4 “Digital Garage” нь захиалгын нийт үнийн дүнг 100 хувь урьдчилан хүлээн авснаар захиалга автоматаар баталгаажна.
- 4.5 “Digital Garage” нь Хэрэглэгчид захиалга хийгдсэнээс хойш 30 минутын хугацаанд төлбөр гүйцэтгэх боломжийг олгож байгаа бөгөөд тус хугацаанд захиалгыг цуцлах, өөрчлөх боломжтой.
- 4.6 Хэрэглэгч бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээлэлтэй сайтар танилцаж, захиалгаа давхар нягтлах үүрэгтэй бөгөөд захиалгын төлбөрийг төлсөн бол тус захиалгыг дараах нөхцөлөөс бусад тохиолдолд буцаах, цуцлах боломжгүй.
- 4.7 Хэрэглэгч цахим тасалбар болон купон худалдан авсан тохиолдолд буцаах боломжгүй.
- 4.8 Хэрэглэгчийн захиалсан барааны загвар зөрсөн, гэмтэлтэй байсан тохиолдолд “Digital Garage” нь тус барааг солиулах эсвэл төлбөрийг буцаан олгох сонголтыг олгоно.
- 4.9 “Digital Garage”-н бараа захиалгын тээвэрлэлтийг мэргэжлийн байгууллага хариуцаж гүйцэтгэх тул захиалсан бараа гэмтэлтэй ирсэн тохиолдолд дээрх нөхцөлийн дагуу арга хэмжээ авна.
- 4.10 Хэрэглэгч захиалга хийхдээ тус системд байгаа барааны дэлгэрэнгүй танилцуулга, мэдээллийг сайтар судлах зайлшгүй шаардлагатай. Хэрэглэгч тус барааны талаар сайтар мэдээлэл аваагүйгээс болж захиалга хүргэгдэн ирсний дараа захиалгыг буцаах хүсэлтийг “Digital Garage” хүлээн авах, барааг буцаах боломжгүй.
- 4.11 “Digital Garage”-д авто үйлчилгээний барааны албан ёсны бренд, бүтээгдэхүүний нэр, код зэрэг мэдээлэл байгаа тул бусад мэдээллийн сувгийг ашиглан тус барааны талаар мэдээлэл, бусад орны хэрэглэгчдийн санал гомдлыг судлах боломжтой.
- 4.12 “Digital Garage” нь 4.10-д заасан нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хэрэглэгчид захиалгаа баталгаажуулах 30 минутын хугацааг олгож байгаа бөгөөд захиалгын төлбөр хийгдэж, захиалгаа баталгаажуулсны дараа Хэрэглэгч нь 4.6-д заасан нөхцөлөөс бусад тохиолдолд захиалгыг цуцлах боломжгүй.
- 4.13 Цахим зээлээр худалдан авалт хийсэн хэрэглэгч захиалгаа өөрийн хүсэлтээр цуцлах нөхцөлд зээлийг судалсан үйл ажиллагаанд зарцуулагдсан зээлийн үйлчилгээний шимтгэлийг буцаан шилжүүлэх боломжгүй.

## **5. Digital Garage оюуны өмчтэй холбоотой эрхийг хамгаалах**

- 5.1 Онлайн худалдааны программ хангамж болох “Digital Garage” вебсайт болон аппликэйшн нь “Цахим Дижитал Гараж” ХХК-ийн зохиогчийн эрхтэй оюуны өмч болно. Энэхүү гар утасны аппликэйшн болон вэбсайтын лого, нэр, бүтэц, загвар, контентыг хуулах, олшруулах, дуурайх, бусад хэлбэрээр ашиглах болон бусад этгээдийн зүгээс ашиг олох зорилгоор ашиглахыг хориглоно.

5.2 “Цахим Дижитал Гараж” ХХК-ийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн тохиолдолд холбогдох этгээдэд Оюуны өмчийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## 6. Захиалгын хүргэлт хийгдэх байршил, хүргэлтийн төлбөр

### 6.1 Хэрэглэгчийн захиалгыг Улаанбаатар хот дотор


1. А бүсэд Энгийн хүргэлт - 6,000 төгрөг, 24-48 цагт хүргэгдэнэ.
2. А бүсэд Шуурхай хүргэлт - 12,000 төгрөг, 2-5 цагт хүргэгдэнэ.
3. Б бүсэд Энгийн хүргэлт - 12,000 төгрөг, 24-72 цагт хүргэгдэнэ.
4. Б бүсэд Шуурхай хүргэлт - 24,000 төгрөг, 2-5 цагт хүргэгдэнэ.

Овор ихтэй бараа бүтээгдэхүүн бүхий захиалгын хүргэлтэд нэмэлт тооцоо нэмэгдэнэ.

Хот доторх хүргэлт нь Улаанбаатар хотын дараах хязгааруудад хийгдэнэ. Үүнд:


#### А бүсийн тойрогт:

Хүргэлтийн А Бүс



#### Б бүсийн тойрогт:

Хүргэлтийн В Бүс



6.2 Дээр заасан хязгаараас гадагш Хэрэглэгчийн хүсэлтээр хүргэлт хийх тохиолдолд тусгай үнийн тариф бодогдоно, орон нутгийн хүргэлтийг тухайн орон нутаг руу тээврийн болон шуудангийн үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний байгууллагаар хүргүүлнэ. Үйлчилгээний хөлс болон үүсэх эрсдэлийг Хэрэглэгч хариуцна.

6.3 Бараа бүтээгдэхүүний хүргэлт Дархан, Эрдэнэт хот руу хийгдэх нөхцөлд тухайн хотууд руу тээврийн болон шуудангийн үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний байгууллагад эсхүл унаанд хүргүүлнэ. Хүргэлтийн төлбөр Үйлчилгээний хөлс нь дээр дурдсан бүсчлэлийн дагуу бодогдоно. Бараа бүтээгдэхүүнийг унаанд эсхүл тээврийн үйлчилгээний машинд тавиж өгсөнөөс хойших хүргэлтэй холбоотой болон бусад үүсэх эрсдэлийг Хэрэглэгч хариуцна.

**Овор ихтэй бараа бүтээгдэхүүн бүхий захиалгын хүргэлтэд нэмэлт тооцоо нэмэгдэнэ.**

- 6.4 Хэрэглэгч бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах хаяг, холбоо барих утасны дугаараа /маш тодорхой/ үнэн зөв бөглөх үүрэгтэй ба буруу мэдээллээс болж үүдэн гарах зардал, алдагдлыг Хэрэглэгч хариуцна. Хүргэлт хийгдэх цагаар утсаа нээлттэй байлгах, хаяг дээрээ байх шаардлагатай.
- 6.5 Хэрэглэгч бичиг баримт шалгуулах шаардлагатай барааг хүлээн авахдаа бичиг баримтаа хүргэлтийн ажилтанд шалгуулан, бараа бүтээгдэхүүнээ шалган хүлээн авна. Үүнд:

- Цахим зээлээр худалдан авсан захиалгын бараа бүтээгдэхүүн

- 6.6 Худалдан авалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл Хэрэглэгчийн бүртгүүлсэн цахим хаяг, бүртгүүлсэн гар утас руу тогтмол илгээгдэх ба Хэрэглэгч өөрийн захиалгын түүх дотроосоо харах боломжтой.
- 6.7 Хүргэгдсэн бараа, бүтээгдэхүүнийг буцаах, солиулахтай холбоотой харилцааг энэхүү үйлчилгээний нөхцөлийн 7 дугаар бүлэгт заасан “Бараа, бүтээгдэхүүнийг буцаах, солих журам”-ыг баримтлан шийдвэрлэнэ.
- 6.8 Хэрэглэгч нь захиалгын мэдээлэл хүргэж буй “Захиалга” хэсэгт байгаа “Санал хүсэлт” эсхүл “Гомдол”-ийг бөглөн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар болон хүргэлттэй холбоотой үнэлгээ өгөх эрхтэй.

**7. Бараа бүтээгдэхүүн буцаах, солих журам**

- 7.1 Хэрэглэгчийн хүлээн авах захиалгын бараа нь дараах төрөлд ангилагдана. Үүнд:

7.1.1 Акт үйлдэх шаардлагатай буюу цахилгаан бараа болон лацтай бараа бүтээгдэхүүн;

7.1.2 Бусад буюу энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол, захиалсан өнгө, хэмжээ зөв эсэх, доголдол бий эсэхийг шалгаж хүргэлтийн ажилтны бараа хүлээлцэх хуудсанд гарын үсэг зурж хүлээн авна.

- 7.2 Хэрэглэгч захиалсан бараа бүтээгдэхүүнийг зохих ёсоор хүлээж авснаа хүлээн зөвшөөрч бараа хүлээлцэх хуудсанд гарын үсэг зурсан тохиолдолд дараах тохиолдлуудаас бусад шалтгаанаар буцаах болон солиулах боломжгүй.

7.2.1 Дараах тохиолдолд бараа бүтээгдэхүүнийг буцаах боломжтой. Үүнд:

- Захиалсан бараа хүлээн авах үед гэмтэлтэй байсан.
- Захиалсан барааны хэмжээ томдсон/багадсанаас шалтгаалан барааг солиулах хүсэлт гаргасан боловч сольж авах бараа дууссан; /Таны захиалсан барааны хэмжээ мөн боловч брендийн болон загварын онцлогоос шалтгаалан таны автомашинд томдох/жигигдэх/таарахгүй нөхцөл байдал үүсэж

болно. Энэ тохиолдолд барааг солиулах сонголт байх бөгөөд солих бараа байхгүй үед захиалгаа буцааж болно.

7.2.2 Дараах тохиолдолд бараа бүтээгдэхүүнийг солих боломжтой. Үүнд:

- Захиалсан барааг хүлээн авах үед загвар, хэмжээ, өнгө зөрсөн; /Өнгө, хэмжээ, загвараас солиулах боломжгүй нөхцөлд өөр төрлийн бараа, бүтээгдэхүүнээс сонгож зөрүүг нэмж төлөх, эсхүл буцаах эрхтэй.
- Захиалсан бараа гэмтэлтэй, зохих ёсоор бүрэн ажиллахгүй байсан

7.2.3 Нийлүүлэгч байгууллагын бараа бүтээгдэхүүний онцлог, хүргэлтийн нөхцөлөөс шалтгаалан гэмтэл, доголтойгоос бусад тохиолдол буцаах, солих дээрх журам үйлчлэхгүй. Иймд та бараа бүтээгдэхүүнээ захиалахдаа өөрийн автомашины модел, төрөл, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн загвар, хэмжээгээ сайтар тооцож тухайн бараа бүтээгдэхүүний талаарх мэдээллийг бүрэн шалгасны үндсэн дээр захиалгаа хийх шаардлагатайг анхаарна уу.

7.3 Хэрэглэгч худалдан авсан барааг буцаах тохиолдолд барааг хүлээн авсан цагаас хойш 24 цагийн дотор 72003003 утсаар эсвэл info@garage.mn цахим хаягаар захиалга өгснөөр буцаах боломжтой. Буцаах барааг өөрийн биеэр буцаах эсвэл өөрийн байгаа газраас авхуулж болно.

7.4 Барааг буцаах үед анхны хүргэлтийн төлбөр /Бүсчлэл, орон нутгийн хүргэлт байршлаас хамааруулан/-ийг тухайн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрөөс суутгаж авна. Хэрэв өөрийн байгаа газраасаа барааг авхуулах тохиолдолд анхны хүргэлтийн хөлс дээр нэмж буцаалтын хүргэлтийн хөлс /А бүс-6,000 төгрөг, Б бүс-12,000 төгрөг, орон нутгийн хүргэлт байршлаас хамааруулан тооцоолж/-ийг суутгах болно.

7.5 Хуваан төлөх төлбөрийн хэрэгслээр худалдан авалт хийсэн хэрэглэгч бараа бүтээгдэхүүнийг буцаах, солих нөхцөлд /бараа бүтээгдэхүүнийг өөрийн биеэр буцаах үед/ худалдан авалтын үнийн дүнгийн 1% болон тухайн бараа бүтээгдэхүүний анхны хүргэлтийн хөлсийг бүсчлэлээс хамааруулан /А бүс-6,000 төгрөг, Б бүс-12,000 төгрөг, орон нутгийн хүргэлт байршлаас хамааруулан/ Цахим Дижитал Гараж-д төлсний үндсэн дээр хуваан төлөх төлбөрийн хэрэгслийн зүгээс таны урьдчилан төлсөн төлбөрийг буцаан шилжүүлнэ. Хэрэв та өөрийн байгаа газраасаа барааг авхуулах тохиолдолд дээрх төлбөр дээр нэмж буцаалтын хүргэлтийн хөлс /А бүс-6,000 төгрөг, Б бүс-12,000 төгрөг, орон нутгийн хүргэлт байршлаас хамааруулан/-ийг нэмж төлнө.

7.6 Бараа бүтээгдэхүүнийг буцаах/солиулахад тухайн худалдан авсан бараа бүтээгдэхүүний тооцооны хуудсыг үндэслэх ба бараа бүтээгдэхүүн нь дахин худалдаалах боломжтой байна.

- 7.7 Сав баглаа боодлыг онгойлгосон болон эвдэрч гэмтсэн, бохирдсон тохиолдолд солих болон буцаах боломжгүй.
- 7.8 Авто үйлчилгээний тос тосолгооны материал, задгай савлагаатай г.м бараанд солих/буцаах нөхцөл үйлчлэхгүй.
- 7.9 Хэрэглэгч шууд төлөлтөөр хийсэн захиалгаа буцаасан нөхцөлд мөнгөн буцаалтыг хэрэглэгчийн нэр дээрх дансанд 48 цагийн дотор шилжүүлнэ.
- 7.10 Хэрэглэгч хуваан төлөлтийн хэрэгсэл (storepay, rocketzero гэх мэт) ашиглан хийсэн захиалгаа буцаасан нөхцөлд буцаалтын хүсэлтийг хүлээн авснаас хойш 72 цагийн дотор шийдвэрлэнэ.
- 7.11 Хэрэглэгч хуваан төлөлтийн хэрэгсэл (storepay, rocketzero) ашиглан хийсэн захиалгаа буцаасан нөхцөлд буцаалтын дүнг хэрэглэгчийн дансанд шилжүүлнэ.
- 7.12 Хэрэглэгчийн мөнгөн буцаалтыг буцаахдаа зөвхөн төлбөр төлсөн дугаар (данс эзэмшигчийн нэр) данс руу буцаана

## **8. Хэрэглэгчийн гомдол, маргаан шийдвэрлэх**

- 8.1 Хэрэглэгч “Digital Garage”-н үйл ажиллагаанд холбогдуулж санал хүсэлт, гомдол гаргах эрхтэй бөгөөд санал хүсэлт, гомдлыг цахим хэлбэрээр “Digital Garage”-н Захиалга хэсгийн “Санал хүсэлт болон Гомдол илгээх” хэсгийг бөглөж гаргана.
- 8.2 Хэрэглэгч нэн тэргүүнд санал хүсэлт, гомдлоо дээр дурдсан хэлбэрээр буюу Garage.mn-тэй шууд холбогдон гаргах бөгөөд “Цахим Дижитал Гараж” ХХК-ийн нэр хүнд болон үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж компанийн нэр хүндэд халдахуйц байдлаар олон нийтийн хэрэгслээр мэдээлэл түгээх зэргээр хориглосон аливаа үйлдлийг гаргахгүй байх үүрэгтэй.
- 8.3 Хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч формд үлдээсэн утасны дугаар, цахим хаягаар холбогдож хэр хугацаанд хэрхэн шийдэх тухай мэдэгдэнэ. “Digital Garage” таны асуудлыг судлаад өгсөн хариу болон авсан арга хэмжээнд та сэтгэл хангалуун бус байгаа тохиолдолд та Монгол Улсын шүүхэд хандаж маргааныг шийдвэрлүүлэх боломжтой.

## **9. Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал**

- 9.1 Хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг “Нууцлалын бодлого”-оор зохицуулна.

## **10. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл**

- 10.1 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын энэхүү үйлчилгээний нөхцөлд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор цахим шуудангаар дамжуулан мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

10.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь нэг сараас дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

10.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс гэдэгт талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, урьдчилан сэргийлж, шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглан даван гарах боломжгүй дараах саад тотгор тохиолдсоны улмаас талууд энэхүү Үйлчилгээний нөхцөлд заасан үүргээ биелүүлж чадахгүйд хүрэхийг ойлгоно. Үүнд:

- Зарласан болон зарлаагүй дайн, зэвсэгт мөргөлдөөн, бослого, гадаадын түрэмгийлэл, хорлон сүйтгэх ажиллагаа, хувьсгал;
- Байгалийн бүх төрлийн гамшиг /гал түймэр, газар хөдлөлт, хүчтэй хар салхи, шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг/
- Төрийн албан тушаалтны хуулийн дагуух болон хууль бус үйлдэл, эс үйлдэл, эрх зүйн акт, тушаал, захирамж;
- Тэсрэлт, дэлбэрэлт, машин үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эвдрэл, цахилгааны ноцтой гэмтэл; бүх төрлийн хязгаар хориг, өвчин тахал, хорио цээр, хариуцлагаас чөлөөлөгдөх хүсэлтэй талын аж ахуй нэгжид тохиолдсон ажил зогсолт, ажил хаялт;
- Программ хангамж, техник тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, хакер халдлага зэрэг, үүнээс бусад талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

10.4 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талууд хууль болон энэхүү Үйлчилгээний нөхцөлд заасан үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй талууд үүнийг нотолсны дүнд харилцан бие биений өмнө болон гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй.

## **11. Олон улсын захиалга**

### **11.1 Ерөнхий**

11.1.1 Цахим Дижитал Гараж ХХК (цаашид “Компани” “Бид” гэх) нь өөрийн garage.mn вэбсайтаар дамжуулан олон улсын авто үйлчилгээний сэлбэг, бараа материалын худалдааны онлайн платформ эсхүл үйлдвэрлэгч дээрх бараа бүтээгдэхүүн болон бусад брэндийн сэлбэг, бараа материал болон цахилгаан авто үйлчилгээний бараа бүтээгдэхүүний (“Бараа” гэх)-ий мэдээллийг Хэрэглэгч (“Та” “Танд” гэх)-д санал болгож, худалдан авалтыг цахимаар хийх боломжийг олгон зуучилж буй цахим худалдааны платформыг эрхлэн явуулагч болно.

11.1.2 Үйлчилгээний нөхцөлөөр Цахим худалдааны платформыг ашиглан Бараа худалдах, Хэрэглэгч худалдан авахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

11.1.3 Үйлчилгээний нөхцөлд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

“Цахим худалдааны платформ” гэж Хэрэглэгч, олон улсын нийлүүлэгчийг холбох цахим худалдааны дундын платформ болох веб хуудас Garage.mn-г;

“Хэрэглэгч” гэж Үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч, цахим худалдааны платформыг ашиглаж буй иргэний эрх зүй бүрэн чадвар, чадамжтай иргэн, хуулийн этгээдийг;

“Цахим гарын үсэг” гэж Хэрэглэгчийг танин баталгаажуулах үйл ажиллагаанд хэрэглэж буй нэвтрэх нууц үг, баталгаажилтын нэг удаагийн нууц үг, бусад цахим өгөгдлийг;

Та цахим худалдааны платформыг ашиглахаас өмнө Үйлчилгээний нөхцөл, Нууцлалын бодлоготой уншиж, танилцах үүрэгтэй. Үйлчилгээний нөхцөл, Нууцлалын бодлоготой бүрэн танилцаж “Би хүлээн зөвшөөрч байна” гэсэн товчийг идэвхжүүлснээр Таныг эдгээр нөхцөл, бодлогод заасныг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

Цаашид цахим худалдааны платформыг ашиглах, үйлчилгээ авах бүрд Үйлчилгээний нөхцөл, Нууцлалын бодлого үйлчилнэ. Хэрэв Та Үйлчилгээний нөхцөл, Нууцлалын бодлогыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан тохиолдолд платформыг зориулалтын дагуу бүрэн ашиглах боломжгүй болохыг анхаарна уу.

## 11.2 Барааны мэдээлэл баталгаа

11.2.1 Вэбсайт, аппликейшн дээр харагдаж буй үнэ нь зөвхөн Барааны үнэ бөгөөд Хэрэглэгч Барааг худалдан авалт хийх үед Барааны үнэ болон Олон улсын тээвэр, гааль, НӨАТ, хүргэлтийн төлбөрийг тусад нь Хэрэглэгчид харуулсан нэхэмжлэх олгоно.

11.2.2 Компани цахим худалдааны платформын зуучлалын үйлчилгээ үзүүлж байгаа тул платформ дээрх Барааны солилтыг хийх боломжгүй бөгөөд зөвхөн Үйлчилгээний нөхцөлд заасантай адил нөхцөл үүссэн тохиолдолд Компани зөвлөн тусална.

11.2.3 Барааг захиалахдаа Хэрэглэгч өөрөө сайтар судалсны үндсэн дээр мөн нэхэмжлэхтэй танилцаад сонголтоо хийж байгаа тул Бараатай холбоотой үүсэх аливаа эрсдэл, хариуцлагыг Хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.

## 11.3 Төлбөр тооцоо

11.3.1 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.24-т заасны дагуу улс хоорондын шуудан илгээмж нь албан татвараас чөлөөлөгдөх тул барааны үндсэн үнээс хасаж тооцон НӨАТ-ын баримт олгоно.

- 11.3.2 Хэрэглэгч хуваан төлөх үйлчилгээ ашиглан захиалга хийсэн тохиолдолд тухайн хуваан төлөх үйлчилгээний байгууллагын нөхцөлийн дагуу Хэрэглэгч өөрөө төлбөрөө баталгаажуулсны дараа захиалга баталгаажна.
- 11.3.3 Хэрэглэгч хуваан төлөх үйлчилгээ ашиглан захиалга хийсэн тохиолдолд үйлчилгээний нөхцөлийн “Бараа буцаах журам”-ын дагуу буцаалт авах нөхцөл үүсвэл буцаалтыг 72 цагийн дотор Хэрэглэгчийн дансанд буцаана.
- 11.3.4 Хэрэглэгч бэлэн төлөлтийн аргыг ашиглан захиалга хийсэн ба үйлчилгээний нөхцөлийн “Бараа буцаах журам”-ын дагуу буцаалт авах нөхцөл үүсвэл Хэрэглэгчийн төлсөн төлбөрийг 100 хувь 72 цагийн дотор Хэрэглэгчийн хүсэлтээр төлбөр төлсөн дансанд болон хэрэглэгчийн бүртгэл дээрх хэтэвчинд буцаана.

#### 11.4 Тээвэр хүргэлтийн нөхцөл

- 11.4.1 Улс хоорондын тээвэрлэлт нь захиалга хийгдэж төлбөр баталгаажсанаас хойш 14-21 хоногт хэрэглэгчийн гарт хүргэгдэнэ. Хүргэлтийн хоног өөр байж болох бөгөөд тухайн мэдээллийг нэхэмжлэх дээр тусгасан байх бөгөөд нэхэмжлэх-д заасан хугацааны дагуу хүргэлт хийгдэнэ.
- 11.4.2 Хэрэглэгч Барааг хүлээн авах хаяг /маш тодорхой/, холбоо барих утасны дугаараа үнэн зөв бөглөх үүрэгтэй ба буруу мэдээллээс болж үүдэн гарах зардал, алдагдлыг Хэрэглэгч бүрэн хариуцна. Хүргэлт хийгдэх цагаар утсаа нээлттэй байлгах, хаяг дээрээ байх үүрэгтэй.
- 11.4.3 Хэрэглэгч Барааны сав баглаа боодол, захиалсан өнгө, хэмжээ зөв эсэх, доголдол бий эсэхийг шалгаж хүргэлтийн ажилтны аппликэйшнд гарын үсэг зурж хүлээн авна.
- 11.4.4 Хүргэгдсэн Барааг солиулахтай холбоотой харилцааг Үйлчилгээний нөхцөлийн “Бараа солих, буцаах журам”-ыг баримтлан шийдвэрлэнэ.
- 11.4.5 Гаалийн татвар, гаалийн мэдүүлэг:
  - 11.4.5.1 Хэрэглэгчийн Барааг түүвэр ачааны журмаар Олон улс дахь агуулахаас Монгол руу илгээх бөгөөд Бараа нь зөвхөн түүвэр ачаагаар гаальд мэдүүлнэ.
  - 11.4.5.2 Монгол Улсын Гаалийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, дүрэмд зааснаар гаалийн шалгалтад оролцуулах зорилгоор бараа, тээврийн хэрэгсэл, улс хоорондын шуудан илгээмжийг гаалийн байгууллага

саатуулан шалгах эрхтэй. Түүвэр ачааг гаалиар мэдүүлэх үед гаалийн улсын байцаагчийн шийдвэрээр Хэрэглэгчийн барааг тухайлан мэдүүлэх шаардлага үүсэж болно. Энэ тохиолдолд Бараа 3 хүртэл хоног гааль дээр саатах ба Бараа саатсан тухай мэдэгдлийг Хэрэглэгчид өгч, Хэрэглэгчийн мэдээллийг гаалийн байгууллага, албан тушаалтанд өгөх болно.

11.4.5.3 Бараа эвдэрсэн, гэмтсэн тохиолдолд Барааны үнэ, Бараатай холбоотой зардал, хохирлыг тээвэрлэлтийн компани 100% хариуцна. Энэ тохиолдолд тээвэрлэлтийн компани руу холбогдох мэдээллийг дамжуулах үүргийг Компани хүлээнэ.

11.4.5.4 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, бүх нийтийн амралтын өдрүүд, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр хил, гаалийн үйл ажиллагаа саатах, цаг агаарын байдал, хорио цээрийн дэглэм тогтоосон, гамшгийн нөхцөл байдал үүссэн болон бусад хүчин зүйлийн улмаас тээвэрлэлт саатах зэрэг шалтгаанаар тодорхой хугацаагаар захиалгын хүргэлт саатах тухай бүрд Хэрэглэгчид мэдэгдэнэ. Эдгээр нөхцөл байдлууд арилж, захиалгыг хүргэх боломж бүрдэх хүртэл хүргэлтийн хугацаа хойшлогдоно.

## 11.5 Бараа буцах журам

11.5.1 Хэрэглэгчийн захиалга амжилттай баталгаажсан тохиолдолд түүнийг буцаах, цуцлах боломжгүй. Хэрэглэгч тухайн Барааны талаар сайтар судлаагүй, эсхүл өөрийн хүсэж буй захиалгаас өөр захиалга хийсэн, нийлүүлэгч захиалгыг бэлдэж эхлээгүй, эсхүл захиалга агуулах руу хүргэлтэд гараагүй зэрэг нь баталгаажсан захиалгыг буцаах, цуцлах үндэслэл болохгүй

11.5.2 Хэрэглэгч захиалсан Барааг шалган хүлээж авсныг нотолж аппликэйшнд эсхүл бараа хүлээлцэх актад гарын үсэг зурснаар Барааг хүлээн авсанд тооцно.

11.5.3 Захиалга амжилттай баталгаажсан тухай мэдэгдэл илгээгдэн Олон улсын нийлүүлэгч, үйлдвэрлэгчээс

захиалга тэвэрлэгдсэн тохиолдолд захиалга солилт, буцаалт, цуцлалт хийгдэхгүй.

11.5.4 Захиалга амжилттай баталгаажсан тухай мэдэгдэл илгээгдэн захиалга баталгаажсанаас хойш зөвхөн дараах тохиолдолд Олон улсын захиалгын бараанд буцаалт хийх боломжтой байна:

11.5.4.1 Хүлээн авсан Бараа үйлдвэрлэлийн алдаатай, ашиглах боломжгүй, ажиллахгүй байгаа нөхцөлд Хэрэглэгчийн гаргасан Бараа буцаах хүсэлтийг Компани нь нотлох баримтаар Үйлдвэрлэгч, нийлүүлэгч рүү дамжуулж, тухайн Үйлдвэрлэгч, нийлүүлэгч Барааг “Буцаахыг зөвшөөрч байна” гэсэн хариуг өгсөн.

11.5.4.2 Хүлээн авсан Бараа Хэрэглэгчийн захиалгад зааснаас зөрүүтэй /өнгө, тоо, хэмжээ гэх мэт/ нөхцөлд Хэрэглэгчийн гаргасан Бараа солих хүсэлтийг Компани нь нотлох баримтаар Үйлдвэрлэгч, нийлүүлэгчрүү дамжуулж, тухайн Үйлдвэрлэгч, нийлүүлэгч Барааг “Буцаахыг зөвшөөрч байна” гэсэн хариуг өгсөн.

11.5.5 Хэрэглэгч Барааг буцаах хүсэлтийг Барааг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор Барааны бичлэг, зураг гэх мэт нотлох баримтын хамт info@garage.mn цахим хаяг болон <https://www.facebook.com/digital.garage.mn/>-т мэдэгдээгүй тохиолдолд Бараа буцаалт хийгдэхгүй.

11.5.6 Үйлчилгээний нөхцөлд зааснаас бусад тохиолдолд буцаах журам үйлчлэхгүй. Иймд та Бараагаа захиалахдаа өөрийн биеийн хэмжээ, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн загвар, хэмжээгээ сайтар тооцож тухайн Барааны талаарх мэдээллийг бүрэн шалгасны үндсэн дээр захиалгаа хийх шаардлагатайг анхаарна уу.

## 12. Бусад

1. “Цахим Дижитал Гараж” ХХК нь Үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд өөрчлөлт оруулсан тохиолдолд тухай бүр garage.mn вэбсайт болон Дижитал Гараж аппликэйшн дээр нийтэд нээлттэй нийтлэх бөгөөд Хэрэглэгч нь танилцах үүрэг хүлээнэ.
2. Хэрэглэгчийг захиалга хийгдэх үед хүчинтэй байсан үйлчилгээний нөхцөл захиалгыг хүргэх шатанд өөрчлөгдсөн тохиолдолд өмнөх үйлчилгээний нөхцлийг үндэслэн бараа, бүтээгдэхүүнийг хүлээж авах хүртэлх хугацаанд хүчинтэйд тооцох болно.